

БАТЛАВ:
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
..... С.ГАНТӨМӨР



**ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**ХОВД ҮЕРИЙН ДАЛАН, СУВАГЧЛАЛЫН АЖЛЫН
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

/Бугат, Хайрхан, Алагтолгой, Бичигт, Баатархайрхан, Тахилт/

Ховд аймгийн Жаргалант сум

2019 он

**[ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР]**

Огноо: 2019.07.02

**ХОВД ХОТЫН ҮЕРИЙН ДАЛАН, СУВАГЧЛАЛЫН АЖЛЫН
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: ХОВД ХОТЫН ҮЕРИЙН ДАЛАН, СУВАГЧЛАЛЫН АЖИЛ

Төслийн дугаар: ХОАЖСЗДТГ/201902063

**Тендер шалгаруулалт / гэрээний нэр: ХОВД ҮЕРИЙН ДАЛАН, СУВАГЧЛАЛЫН АЖИЛ
/Бугат, Хайрхан, Алагтолгой, Бичигт, Баатархайрхан,
Тахилт/**

Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Ховд үерийн далан, сувагчлалын /Бугат, Хайрхан, Алагтолгой, Бичигт, Баатархайрхан, Тахилт багууд/-ын ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг** урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Улаанбаатарын цагаар 11 цаг 00 минут байна.** -аас өмнө **Ховд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 109 тоот өрөөнд** (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж баримт бичгээ (Adobe PDF) шилжүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **Тендерийг 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Улаанбаатарын цагаар 11 цаг 40 минутад Ховд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 109 тоот өрөөнд нээнэ.**

Дотоодны давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт баг Аюурзанын 4-р гудамж 401 Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын байр, 1 давхар 109 тоот утас 99895984

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**

6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /2018 оны тайлан аудитын дүгнэлтийн хамт/ 2. Сүүлийн 1 жилд ижил төстэй ажил жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, ажил хүлээлцсэн актын хуулбар 3. Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатораар батлуулсан хуулбар 4. Шүүхийн байгууллагын тодорхойлолт 5. Нийгмийн даатгалын тодорхойлолт 6. Харилцагч банкны тодорхойлолт 7. Татварын байгууллагын тодорхойлолт 8. Боловсон хүчний мэдээлэл 9. Албан мэдэгдэл /ТӨӨЗ-нд заасан/ байгууллагын тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байна. 10. Борлуулалтын орлогын хэмжээ нь 2018 оны борлуулалтын орлого 30.0 сая төгрөгнөөс дээш байх 11. Авах боломжтой зээлийн хэмжээ төсөвт өртөгийн 40-өөс дээш хувь байна /судлагдсан зээлийн тодорхойлолт, дансны үлдэгдлээр баталгаажуулна/ <p>Тендерт оролцогч нь тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</p> <p>Үүнд: <i>Барилга хот байгуулалтын яамны тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл, шаардлагын 2.2.1. барилга байгууламжийн доторх халаалт, салхивч, усан хангамж, ариутгалын татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт</i></p> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай.</p> <ol style="list-style-type: none"> 1. Авто кран /түрээсийн байж болно. гэрээний хуулбар наторатаар батлуулсан/ 2. Экскватор 0,5 м3/30 ЭО-3322 /түрээсийн байж болно. гэрээний хуулбар наторатаар батлуулсан/ 3. Гүний доргуур 42/мм _UB116 4. Зөөврийн гагнуурын аппарат 5. Үйлчилгээний машин
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт баг Аюурзанын 4-р гудамж 401 Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын байр, 1 давхар 109 тоот</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Уг тендэр нь цахим тендерийн журмаар явагдаж байгаа тул тендэрт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж баримт бичгээ (Adobe PDF) шилжүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Улаанбаатарын цагаар 11 цаг 00 минут байна.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Тендерийг 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Улаанбаатарын цагаар 11 цаг 40 минутад Ховд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 109 тоот өрөөнд нээнэ. Харилцах утас: 99895984</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй Тендерийн баталгаа шаардана.</p>

Батлав Жаргалант сумын Засаг дарга

С.Гантөмөр

дөрөв. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
01. Бугат баг / Цэнгэгийн 1-р гудамж 109 тоот /соёолон дэлгүүрийн урд хар зам/			
1	Чулуут бетон 2 талын амсарт цутгах	М ³	3,80
2	Ус зайлуулах суваг цэвэрлэх	М ³	16,00
3	Замын чигийг сэргээх	1 км	0,01
4	3-6 см зузаантай тоосгыг цахилгаан багаж /чулуу зүсэгч хөрөө/-өөр янз бүрээр хэлбэр дүрс гаргаж зүсэх	1у/м	14.00
5	Засмал замыг сэтгэж хийн доргиурт алхаар ухах	М ³	2,50
6	Бетон бэлтгэл хийх М 50-75	М ³	2,80
7	Ф 600мм 7м урттай яндан хоолой суулгах	М	7,00
8	50 см зузаан үеэр хөрс нягтаршуулагч машинаар нягтруулах	М ³	86,0
9	Сувгийн нүхийг гараар ухах	М ³	22,50
02. Бичигт багт эрх чөлөөний гудамж 2-р гудамж 212 тоот /Цагаан морь захын урд хар зам/			
11	2 м хүртэл гүн шуудуйг бэхэлгээгүйгээр 2-р зэргийн хөрсөнд гараар ухах	М ³	129,36
12	Далангын хажуу налууг цементэн зуурмагтай чулуугаар бэхлэх	1М ²	184,80
03.Хайрхан баг Жуулчны 8-р гудамж 823 тоот хашааны хажуугийн хар замд			
13	Замын чигийг сэргээх	1 км	0,01
14	3-6 см зузаантай тоосгыг цахилгаан багаж /чулуу зүсэгч хөрөө/-өөр янз бүрээр хэлбэр дүрс гаргаж зүсэх	1у/м	14.00
15	Засмал замыг сэтгэж хийн доргиурт алхаар ухах	М ³	2,50
16	Бетон бэлтгэл хийх М50-75	М ³	2,80
17	Ф 600мм 12м урттай яндан хоолой суулгах	м	12,00
18	50 см зузаан үеэр хөрс нягтаршуулагч машинаар нягтруулах	М ³	56,0
04.Тахилт баг Ахмадын 1-р гудамж 101 тоот / Молор дэлгүүрийн			
19	Замын чигийг сэргээх	1км	0.028
20	3-6см зузаантай замыг цахилгаан багаж/чулуу зүсэгч хөрөө/-аар янз бүрээр хэлбэр дүрс гаргаж зүсэх	1у/м	28.00
21	Засмал замыг хийн доргиурт алхаар ухах	М ³	5.00
22	Бетон бэлтгэл хийх М50-75	М ³	5.60

23	Ф600 мм яндан хоолойг суулгах	м	14.00
24	Чулуут бетон Трап хэлбэрийн амсар цутгах	М ³	7.60
25	Сувгийг цементэн зуурмаг чулуугаар доторлох	100 М ³	0.73
26	50см зузаан үеэр хөрс нягтруулагч машинаар нягтруулах	М ³	56.0
05 Алагтолгой баг /Замчдын 4-р гудамж 442 тоот Молор дэлгүүрийн /			
27	Замын чигийг сэргээх	1км	0.07
28	3-6см зузаантай засмал замыг цахилгаан багаж/чулуу зүсэгч хөрөө/-аар янз бүрээр хэлбэр дүрс гаргаж зүсэх	1у\м	14.00
29	Засмал замыг хийн доргиурт алхаар ухах	М ³	2.50
30	Бетон бэлтгэл хийх М50-75	М ³	2.80
31	Ф600 мм яндан хоолойг суулгах	м	7.00
32	Чулуут бетон амсар цутгах	М ³	3.80
33	50см зузаан үеэр хөрс нягтруулагч машинаар нягтруулах	М ³	28.00
34	Суваг болон голын эрэг орчмыг цементэн зуурмагтай чулуун өрлөгөөр бэхлэх	100 М ³	0.72
06 Баатархайрхан баг / Манлайбаатарын 4-р гудамж 411 тоотын хажуу хар зам/			
35	Замын чигийг сэргээх	1км	0.07
36	3-6см зузаантай засмал замыг цахилгаан багаж/чулуу зүсэгч хөрөө/-аар зүсэх	1у\м	14.00
37	Замыг хийн доргиурт алхаар ухах	М ³	2.50
38	Бетон бэлтгэл хийх М50-75	М ³	2.80
39	Ф600 мм яндан хоолойг суулгах	м	7.00
40	50см зузаан үеэр хөрс нягтруулагч машинаар нягтруулах	М ³	56.00
41	Далангийн хажуу налууг чулуугаар бэхлэх	1м ²	96.00
42	Сувгийн 2 талын амсар чулуут бетон цутгах	100м ³	0.06
07 Баатархайрхан баг / Хатанбаатарын 2-р гудамж 200 тоот /			
43	Замын чигийг сэргээх	1км	0.07
44	3-6см зузаантай засмал замыг цахилгаан багаж/чулуу зүсэгч хөрөө/-аар янз бүрээр хэлбэр дүрс гаргаж зүсэх	1у\м	14.00
45	Замыг хийн доргиурт алхаар ухах	М ³	2.50

46	Бетон бэлтгэл хийх М 50-75	М ³	2.80
47	Ф600 мм яндан хоолойг суулгах	м	7.00
48	Чулуут бетон 2 талын амсарт цутгах	М ³	3.80
49	50 см зузаан үеэр хөрс нягтруулагч машинаар нягтруулах	М ³	42.00
50	Суваг болон голын эрэг орчмыг цементэн үуурмагтай чулуун өрлөгөөр бэхлэх	100 М ³	0.06

Боловсруулсан:

Статистикийн мэргэжилтэн

 Х.Ганболд

Хянасан:

ХАА, дэд бүтэц хариуцсан
Засаг даргын орлогч

 Ц.Цогтбаяр

БАТЛАВ. ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

С.ГАНТӨМӨР



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ШААРДЛАГА :

1. Гүйцэтгэгч нь ажлын талбайд гэрээ байгуулсаны дараа 3 хоногийн дотор Компаний товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажлын нэр, гэрээний үнийн дүн, ажил эхлэх болон дуусах хугацаа зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар байрлуулсан байна.
2. Гүйцэтгэгч нь ашиглагч, захиалагч байгууллагуудтай уялдаатай ажиллах бөгөөд гэрээнд заасан хугацаан дотор ажил гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.
3. Гүйцэтгэгч үе шатны ажлын үед зохиогч болон захиалагчийг дуудаж далд ажлын акт үйлдэж баталгаажуулна.
4. Ажлын тоо хэмжээг гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт болон зурагтай холбож ойлгоно.
5. Ажлын тоо хэмжээнд тодорхойлсон магадлашгүй ажлын зардлыг зарцуулахад захиалагчийн зөвшөөрөл баталгааг авна.
6. Үнэлсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан үнэ өртөгийн ажлын тоог заасан заагаагүй, аль ч нөхцөлд тодорхойлсон байна. Гүйцэтгэгчийн бөглөөгүй орхисон үнэ өртөг, тодорхойлоогүй үлдээсэн ямар нэгэн ажил, түүний үнэ өртөг нь ажлын хэмжээнд тусгасан бусад ажлуудад шингэсэн гэж ойлгоно.
7. Гүйцэтгэгч нь ажилтнуудаа хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангаж, тухайн орчин, ажлын байр, зам гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, үйлдвэрлэлийн ослоос урдчилан сэргийлэх арга хэмжээг авч, хашаа хамгаалалт байгуулж, оршин суугчдын зорчих хэсгийг зааглаж, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг хийж, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж ажиллах ба үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна. Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.
8. Ажлыг гүйцэтгэх үед тухайн орчны тохижилт, холбоо, цахилгаан, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.
9. Тухайн гүйцэтгэсэн ажилдаа Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 дахь заалтуудын дагуу тохируулга, ашиглалтын хугацааны баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.

**“Хайрхан , Бугат, Алагтолгой, Баатархайрхан , Тахилт, Бичигт багуудын
7 байршилд автозамд үерийн ус зайлуулах хоолой,
суваг байгуулах ажлын техникийн тодорхойлолт
ажлын даалгавар**

Ховд аймгийн Засаг даргаас эрх шилжиж ирсэн Хайрхан , Бугат, Баатархайрхан , Тахилт, Бичигт багуудын 7 байршилд “Авто замуудад Үерийн хамгаалалтын далан, суваг, ус зайлуулах хоолой хийх” ажлын техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагыг тусгав.

ХИЙГДЭХ АЖЛУУД :

- Барилга байгууламжийн трассын байрлалд улаан шугам тавих, шаардлагатай бэлтгэл ажил хийх
- Трассын дагуу ухлага хийж, суурь бэлтгэл ажил хийх,
- Ус зайлуулах суваг, доторлогооны ажил хийх,
- Трассын дагуу асфальтан замд зүсэлт хийж, хуулах,
- Автозамд ухлага хийх,
- Суурийн бэлтгэл ажил, Хоолой угсарч суурилуулах, хүчитгэх
- Үерийн ус тосох болон гаргах байгууламжийн төмөр бетон цутгалтын ажил
- Бусад нэмэлт ажил

ХИЙГДЭХ АЖЛЫН БАЙРШИЛ, ТОО ХЭМЖЭЭ :

№	Ажлын байршил, нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1.	Бугат баг Цэнгэгийн 1-р гудамжны 109 тоот хашааны урьд талын хар замын хоолой цэвэрлэх, сэтгэж бөглөөсийг гаргах, үерийн 240 м суваг татах /Соёолон дэлгүүртэй гудамж олны нэршил/	м	240
2.	Бичигт багийн Эрх чөлөөний 2-р гудамжны 212 тоот хашааны эсрэг тал Цагаан морин захын урд хар замыг сэтлэж усны хаялга хоолойг байруулж, 134 м суваг татаж үерийн төв шугамтай нийлүүлэх, эсрэг талын 20 м сувагчлал хийх	м	154
3.	Хайрхан баг Жуулчны 8-р гудамжны 823 тоот хашааны өнцөгт хар замыг сэтэлж суваг гаргах	м	12
4.	Тахилт баг Ахмадын 1-р гудамж 101 тоот хашааны урд талын хар зам сэтэлж шинээр суваг хоолой тавих /Молор дэлгүүрийн урд тал суваг хийх /	м	61
5.	Алагтолгой багийн Замчдын 4-р гудамжны 442 тоот хашааны ар талаар хар замд шинээр хоолой суулгах /Молор дэлгүүрийн ар талын гудамж/	м	62
6.	“Баатархайрхан багийн Манлайбаатарын 4-р гудамжны 411 тоот хашааны ар талд хар зам сэтлэж хоолой тавих сувгийн ажил 80 м х	м	80

7.	Баатархайрхан багийн Хатанбаатарын 2-р гудамжны 200 тоот хашааны эсрэг талын хар зам сэтэлж хоолой суулгах усны хаялга гаргах, сувгийн ажил 20 м /7-р сургуулийн дээд талд хар зам олны нэршил/	м	20
----	---	---	----

Үерийн ус зайлуулах шугам хоолойн ажилд 600мм,800мм-ийн төмөр хоолойг ашиглах бөгөөд Үерийн ус тосгуур нь ус хуримтлуулах, цуглуулах талбайтай, ус гаргуур нь ус тосох талбайтай байх ба тус бүртээ 2 чиглүүлэгч далавчтай, Далавчийг чулуу, төмөрбетон зуурмагын хольцоор цутгаж хийнэ. Ус зайлуулах шугам, хоолойн ажил болон Угсармал төмөрбетон бүтээцийг байгуулахдаа “Усны барилга байгууламжийн бетон ба төмөрбетон бүтээц” БНБД33-06-09 нормыг удирдамж болгосон байна.



Борооны ус зайлуулах суваг нь трапеци хэлбэртэй, 60см-ээс багагүй гүнтэй чулуун болон төмөрбетон доторлогоотой байх бөгөөд ус зайлуулах хоолойн ус цуглуулах хуримтлуулах талбай руу шууд холбогдож усаа юүлдэг хэлбэртэй байна.

Ерөнхий шаардлага :

- *Гүйцэтгэгч нь хуучин инженерийн байгууламжийн ойр орчмын газарт ухалтын ажил эхлэхээс өмнө юмуу энэ ажил нь инженерийн байгууламжуудад нөлөөлөхүйц шинжтэй байвал, тэдгээр инженерийн байгууламжуудыг эзэмшигч юмуу тэдгээрийг хариуцаж буй холбогдох байгууллагуудад мэдэгдэж, инженерийн заавраар ажлаа үргэлжлүүлэхээс өмнө тэдгээр байгууламжийг хэрхэн хамгаалах, сэргээн засварлахаар төлөвлөсөн өөрийн ажлын төлөвлөгөөгөө тэдгээр холбогдох байгууллагуудад танилцуулж зөвшөөрөл авна.*
- *Гүйцэтгэгч дараахь бүх инженерийн байгууламжийн нарийвчилсан байршил болон холбогдох хэсгүүдийг тогтоох үүрэгтэй. Үүнд :*
 - *Бохирын шугам,*
 - *Гадаргын ус зайлуулах шуудуу,*
 - *Цахилгааны утас, гэрэлтүүлгийн кабель шугам*
 - *Өндөр хүчдэлийн цамхагийн шон,*
 - *Кабелийн суваг хоолой*
 - *Ус дамжуулах шугам*
 - *Дулаан дамжуулах шугам гэх мэт...*
- *Гүйцэтгэгч, аливаа хуучин хийгдсэн зүйл, инженерийн байгууламж, шугам сүлжээг эвдэж гэмтээсэн тохиолдолд хариуцлагыг хүлээж, захиалагчтай холбогдож, гарсан аливаа хохиролыг барагдуулна. Гэмтсэн бүх инженерийн байгууламжийг нөхөн сэргээх ажлыг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.*
- *Замын ажлыг эхлэхээс өмнө тээврийн хэрэгслийн чөлөөтэй хөдөлгөөнийг хангасан түр зам, дөхөх замыг байгуулж, түр ба дөхөх замын хөдөлгөөнд хөдөлгөөнийг зохицуулах **урсгал хаасан , хориглосон , тойрч гарах** гэсэн тэмдэгүүдийг анхааруулж тавина.*
- *Тухайн орчин дахь оршин суугчдад зам барилгын ажил эхлэхийг урьдчилан анхааруулсан байхаас гадна ажиллах арга ажиллагаа нь ард иргэдийн буюу*

- өөрийн ажиллагсадын эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хөнөөл учруулахгүй байх нөхцлийг хангасан байна. Зам барилгын ажил гүйцэтгэж байгаа гүйцэтгэгч эдгээр болон бусад шаардлагатай бүхий л хөдөлмөр хамгаалал болон аюулгүй ажиллагааг баримтална.
- Газар шорооны ажил гүйцэтгэх, хучилтын суурь үеийг дэвсэх болон нягтруулахад ашиглах бүх тоног төхөөрөмж нь зохих хүчин чадалтай, ашиглалтын үзүүлэлт сайтай байх ёстой бөгөөд Машин механизм нь гэрлэн ба дуут дохиотой, тоног төхөөрөмж нь техникийн хувьд бүрэн бүтэн , ажиллагсад нь хувийн хамгаалах хэрэгсэлтэй байх ёстой.
 - **Ажлын үе шат бүрт фото зураг авч, далд ажлын акт бичиж баталгаажуулна.**
 - Ухлагын ажилд **“Барилгын газар шороо ба буурь суурийн ажил” БНБД 3.02.01-16** нормыг удирдамж болгоно.
 - Угсармал төмөрбетон бүтээцийг байгуулахдаа **“Усны барилга байгууламжийн бетон ба төмөрбетон бүтээц” БНБД33-06-09** нормыг удирдамж болгосон байна.
 - Усанд автагдсан газарт ухлага хийхдээ **БНБД3.01.05-90**-ын заалтыг үндэслэнэ.
 - Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний шинжилгээг **MNS ASTM D422** дагуу тодорхойлно.
 - Хөрсний чийг нягтралын хамаарлыг **MNS ASTM D698** дагуу тодорхойлно.
 - Байгалийн хөрсөн дэх ус чийгийн хэмжээг **MNS ASTM D2216**-д заасны дагуу тодорхойлно.
 - Ухлага хийх хэсэгт төслийн гүн болон өргөний хэмжээсүүдийг газар дээр нь байрлуулж, буулган тэмдэглээг хийн захиалагчийн төлөөлөгчтэй зөвшилцөнө.
 - Шугам хоолойн траншейн трассын тэнхлэгийг теодолитоор буулган, 10м тутам пикетлэсний дараа барилгын ажлыг гүйцэтгэх газарт тохируулан гадаслаж, төслийн ухалга, овоолго хийх тэмдэгтүүдийг бичиж эхлүүлнэ.
 - Ухалгаас гарсан хөрс, чулуулгийг Захиалагчийн төлөөлөгчийн заасан байрлалд байрлуулах ба Ашиглахад тохиромжгүй хөрс материалууд болох өнгөн хөрс органик агуулсан материал болон хөвөгч нойтон материал агуулсан нягтрал авдаггүй элсэн хөрсийг захиалагчийн заавраар зөөвөрлөн аваачиж, тогтвортой байдалд оруулж тарааж орхино.
 - Тухайн ажлын суурьт тохирохгүй хөрсийг сольж, тохирох хөрсийг хийж нягтруулна.
 - Ухлагын байрлал, түвшин нь газрын гадаргын бодит байдлаас хамааран өөрчлөгдөх ба холбогдох стандарт, журамд заагдсан шугам өндөржилтийн түвшин хүртэл ухлагыг гүйцэтгэнэ.
 - Ухлагын ажлын хажуу налуу нь батлагдсан норм, техникийн шаадлага, зохих аюулгүй ба тогтвортой байдлыг хангасан байх ёстой.
 - Экскаватороор траншей ухалга хийсэн газарт гараар тэгшилгээ хийж, зөөврийн хөдөлгөөнт нягтруулах төхөөрөмж болон механик булаар ёроолыг тэгшлэн нягтруулна.
 - Суурийг тэгшилж нягтруулж бэлэн болгосоны дараа элс хайрган бэлтгэл үеийг хийнэ. Элс хайрган бэлтгэл үеийн шаврын агууламж 5%-иас хэтрэхгүй байна.

- Траншейн ёроолын тэгшилж нягтруулсан суурийг бэлэн болгож, хэвгийг шалгасны дараа хоолой угсрах ажлыг эхэлнэ.
- Ус дамжуулах шугам хоолойд ашиглагдах Төмөр эдлэлийн бат бэхийн үзүүлэлт нь төсөлд заасан хэмжээг хангаж байгаа эсэхийг үйлдвэрлэж байгаа байгууллага эсхүл гүйцэтгэгч байгууллага чанарыг баталгаажуулсан байна.
- Холбогдох журам, стандартын дагуу цутгалт, дүүргэлтийн ажлыг зориулалтын зохимжит материал, хар хайрга дайргаар хийж, нягтруулсаны дараа нүхний ёроол, сүвгийн хэсгийн илүүдэл материалыг зайлуулж цэвэрлэх ажлуудыг холбогдох дүрэм, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
- Хучлагын суурь ба замын даланд гадаргуугийн ус нэвтрэн орж, нийт хийцийн даацын үзүүлэлтийг бууруулах, хучлагын нийт хэсэгт эвдрэл үүсгэхээс урьдчилан сэргийлэх, замын тэгш байдлыг хангаж, тээврийн хэрэгслийн жигд хурдтай зорчих нөхцлийг бүрдүүлэх үүднээс хучилтын гадаргуугийн тэгш байдал нь хуучин замын нийт хэсгийн тэгш байдалтай ижил нэг түвшинд, ижил буюу илүү зузаантай байна.




Боловсруулсан:

Статистикийн мэргэжилтэн

 Х.Ганболд

Хянасан:

ХАА, дэд бүтэц хариуцсан
Засаг даргын орлогч

 Ц.Цогтбаяр

Тав.. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын нэр	Ажлын тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан (Ажлын талбай)	Ажил хийж дуусгах хугацаа		
					Ажил эхлэх хамгийн эхний хугацаа	Ажил дуусах эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8

Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор

хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээ
с чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ХОВД ҮЕРИЙН ДАЛАН, СУВАГЧЛАЛЫН АЖИЛ /Бугат, Хайрхан, Алагтолгой, Бичигт, Баатархайрхан, Тахилт/ ХОАЖСЗДТГ/201902063
ГЕН 2.1	Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь /Жаргалант сумын Бугат, Хайрхан, Алагтолгой, Бичигт, Баатархайрхан, Тахилт багуудын авто зам дагуу байршил] -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь Ц.Цогтбаяр Засаг даргын орлогч
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2019,07,15 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2019,08,15
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 365 хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,1 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 5 хувь байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 2019,09,01 -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг 2019,08,20 -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 10000 төгрөг байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0,1 хувь -иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]